ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
ЗОРИЛТ 1. ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ							
1.1	Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	50,0	Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 67%	Хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь 80%-иас доошгүй байна.	"Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр 2025-2028" үйл ажиллагаа 2026 оны эхний хагас жилийн байдлаар 67,8%-ийн хэрэгжилттэй байна. Нэгдүгээр хавсралтаар дэлгэрэнгүй тайланг хавсаргав.	70%
1.2	Зонхилон тохиолдох хорт хавдрын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	20,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай.	Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-иас доошгүй байна.	Хүн амын дунд хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг идэвхжүүлэх зорилтын хүрээнд зонхилон тохиолдох 7 байрлалын хорт хавдарт чиглэсэн үндсэн 7 үйл ажиллагааг төлөвлөсөн. 2026 оны хагас жилд 3 үйл ажиллагаа хэрэгжсэн; 4 нь 2-р хагас жилд хэрэгжинэ. -1-р сар: "Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх сар"-ын хүрээнд 1 богино бичлэг, 5 мэдээлэл нийтлэсэн. -2-р сарын 4-нд сэтгүүлч 30 гаруй хүнд сургалт зохион байгуулсан. ХСҮТ-ийн Facebook хандалт 9800. Хавдрын эсрэг Дэлхийн өдөрт 7 богино бичлэг нийтэлсэн; Facebook хандалт 575,000. -3-р сар: Бүдүүн гэдэсний хавдраас сэргийлэх мэдээлэл нийтлэсэн. -4-р сар: 4 мэдээлэл, 1 шууд лайв хийж, ЭМЯ-ийн нээлттэй хаалганы өдөрлөгт оролцсон. -5-р сарын 31: "Тамхины эсрэг өдөр–Таны нэгдэх өдөр" өдөрлөгт ХСҮТ-ийн 10 эмч оролцлоо.	100%
1.3	БСТ-3.1.3 Олон улсын ISO	7,0	Стандартын хэрэгжилтийн хувь	Стандартын баталгаажилт	Стандартыг 90 ба түүнээс	Жил бүр ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны давтан	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	9001:2015 стандартын хэрэгжилтийг тасралтгүйгээр хангаж ажиллана.			хийгдсэн. Стандартын хэрэгжилт-80%	дээш хувь хэрэгжүүлсэн байна.	баталгаажилт хийгддэг. -2025.06.12-13-нд баталгаажуулах аудит хийгдэж 0 үл тохирол, 12 сайжруулах боломжтойгоор гэрчилгээ авсан. -2026 оны давтан баталгаажилт 6-р сард хийгдэнэ.	
1.4	БСТ-3.1.4 Дотоод аудитын хөтөлберийг хэрэгжүүлнэ.	12,0	Дотоод аудитын хөтөлберийн дагуу аудитад хамрагдсан нэгжийн тоо; Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2023, 2024 онд 34 тасаг албаны аудит хийгдсэн. 2025 онд 6 тасаг, алба.	Жилийн турш 29 тасаг, алба (улирал бүр 7-8 нэгж). Зөвлөмжийн хэрэгжилт 90%-иас дээш.	ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2026 оны А/03 тушаалаар дотоод хяналтын багийн бүрэлдэхүүн батлагдсан. Аудитын I баг 2026 оны 2-р сард 7 тасаг, алба ISO 9001:2015-ийн 38 шалгуур үзүүлэлтийн дагуу аудитад хамрагдсан: ЦХМЗТ, ЕМЗТ, Хагалгаа-мэдээгүйжүүлэг, Хими эмчилгээ, Хөхний төв, ТХМПНСМЗТ, Нийгмийн эрүүл мэнд, сургалтын алба. Аудитын дүн: "Үл тохирол" илрээгүй. Нийт 31 сайжруулах санал; хэрэгжилт 90.0%. Тасаг тус бүр: ЦХМЗТ 92.1%, ЕМЗТ 90.0%, Хөхний төв 81.6%, ТХМПНСМЗТ 90.0%, ХМНТ 90.0%, Хими эмчилгээ 92.1%, НЭМС,СА 90.0%.	100%
1.5	БСТ-3.1.1 Стандарт үйл ажиллагааны зааварчилгаа (СҮАЗ) болон журмын хэрэгжүүлэлтийг сайжруулж, шинэчлэн боловсруулна.	15,0	Шинэчлэгдсэн СҮАЗ-ны тоо; СҮАЗ-ны хэрэгжилтийн хувь	2020 онд 34 тасаг, алба СҮАЗ боловсруулж эхэлсэн. 2025 онд СҮАЗ шинэчлээгүй.	25 нэгжийн СҮАЗ шинэчилсэн байна. СҮАЗ-ыг тусламж үйлчилгээнд 100% хэрэгжүүлсэн байна.	2026 оны хагас жилд 9 алба, тасаг СҮАЗ-аа шинэчилсэн: Сувилахуйн алба, Амбулаторийн тасаг, Даатгал статистикийн алба, Мэдээлэл технологийн алба, Химийн тасаг, ЦХМЗТ, ТХМПНСМЗТ, Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг, Элэг цөс нойр булчирхайн мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгах төв. Бүх алба, тасаг СҮАЗ-аа тусламж үйлчилгээндээ 100% хэрэгжүүлж байна.	70%
1.6	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн ХПВ-ын шинжилгээнд хамрагдсан	1950,0 (ЭМДС)	ХПВ-ын шинжилгээнд хамрагдсан зорилтот насны	Улаанбаатар хотын 5382 эмэгтэйг ХПВ илрүүлэгт хамруулсан.	Зорилтот насны (30, 40) ≤18,000 эмэгтэйг ХПВ-ын шинжилгээнд	1. Үндэсний хэмжээнд: 2026.03.22–04.29 ДЭМБ-ийн санхүүгийн дэмжлэгтэй ЭМЯ, ХСҮТ хамтран сургалт зохион байгуулж 660 өрх, сум, тосгоны эмч мэргэжилтэн ХПВ сорьц авах, тээвэрлэх, зөвлөгөө өгөх аргад	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	зорилтот насны /30, 40/ эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлнэ.		эмэгтэйчүүдийн тоо		хамруулсан байна.	сурапцлаа. 2. 2026 оны 6-р сард UNITAID болон ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр Монгол Улсад 20,000 Gene-Xpert HPV тестийн багц нийлүүлэгдэхээр хүлээгдэж байна. Ингэснээр умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг ХПВ шинжилгээ рүү шилжих суурь бэлтгэл хангагдаж байна.	
1.7	Хэмжилт тохируулгын симулятор худалдан авч, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдэд шалгалт, тохируулга, хяналт хийнэ.	180,0	Худалдан авсан тоног төхөөрөмжийн тоо; Хэмжилт тохируулга хийсэн тоног төхөөрөмжийн эзлэх хувь	Хяналт, тохируулга хийх шаардлагатай 270 эмнэлгийн тоног төхөөрөмж байна.	Нэн шаардлагатай хэмжилт тохируулгын 3 симулятор авсан байна. Хяналт, тохируулгад орох тоног төхөөрөмжийн 30% орсон байна.	Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдэд шалгалт тохируулга хийх симулятор аппаратын судалгаа хийгдэж байна.	30%
1.8	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO/IEC 27001:2022 олон улсын стандартыг нэвтрүүлнэ.	100,0	Батлагдсан журам, зааврын тоо; Мэдээллийн аюулгүй байдлын тохиолдлын мэдээний сан	Стандарт хэрэгжээгүй. Мэдээний сан байхгүй.	ISO/IEC 27001:2022 стандартын 8 журам, заавар боловсруулан батлуулж мөрдсөн байна. Мэдээний сан үүсгэж, зөрчлийн тохиолдол бүрийг бүртгэж хариу арга хэмжээ авсан байна.	2026 оны байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэхээр тусгасан. "Мэдээллийн аюулгүй байдлын ерөнхий журам", "Компьютер тоног төхөөрөмж ашиглах, дотоод сүлжээнд ажиллах журам", "Цэвэр ширээ, цэвэр дэлгэцийн журам" — 3 журам батлагдан мөрдөгдөж байна. ISO/IEC 27005 стандартыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
1.9	БСТ-4.1.3 ISO-15189 стандартыг хэрэгжүүлэгч байгууллага болно.	80,0	Стандартын магадлан итгэмжлэлийн баталгаажсан гэрчилгээ	Итгэмжлэлийн гэрчилгээгүй.	ISO-15189 стандартын магадлан итгэмжлэлийн гэрчилгээтэй болсон байна.	2026 оны хагас жилийн байдлаар: Стандарт ажиллагааны заавар (СА3)-93, Техник ажиллагааны заавар (ТА3)-21, Аюулгүй ажиллагааны заавар-63, Био аюулгүй ажиллагаа болон бусад 5 журам батлагдсан. 29 төрлийн бүртгэлийг шинэчилсэн. ДЭМБ-ийн олон улсын шинжээч мэргэжилтэнээр үнэлгээ хийлгэж, зөвөлгөө авсан.	70%
1.10	Хавдрын сэргээн засах чиглэлээр /толгой хүзүүний хорт хавдрын дараах сэргээн засах/ 1 төрлийн эмчилгээний удирдамж батлуулж, хэрэгжүүлнэ.	16,0 (ЭМДС)	Батлуулсан удирдамжийн тоо; Удирдамжийн дагуу сэргээн засах эмчилгээнд хамрагдсан хүний тоо	Нийт 2 удирдамж батлуулж, 2 удирдамж боловсруулсан. Сэргээн засах эмчилгээнд нийт 627 үйлчлүүлэгч хамрагдсан.	"Толгой хүзүүний хорт хавдрын дараах сэргээн засах" эмчилгээний 1 удирдамж боловсруулж, Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна. Батлагдсан удирдамжийн дагуу 40 үйлчлүүлэгч хамрагдсан байна.	Удирдамжийн боловсруулалт 85%-ийн гүйцэтгэлтэй. 2026 оны 6 сарын 15-нд Эмнэлзүйн хороогоор батлуулна. Удирдамж батлагдсаны дараа үйлчлүүлэгчдийг хамруулахаар бэлтгэл хангасан.	Тайлагнах хугацаа болоогүй
1.11	БСТ-3.1.2 Ходоод, бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдрын эмчилгээ, оношлогооны удирдамжийг шинэчлэн	2,0	Батлуулсан удирдамжийн тоо	ЭМС-ын 2021.11.16-ны А/703 тушаалаар батлагдсан бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн оношилгоо, эмчилгээний	Мэргэжлийн салбар зөвлөлөөр 2 удирдамж боловсруулж батлуулсан байна.	Ходоодны хорт хавдрын эмчилгээ, оношилгооны эмнэлзүйн удирдамж болон бүдүүн-шулуун гэдэсний хорт хавдрын эмчилгээ, оношлогооны 2 удирдамжийг боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн. Батлуулах шатанд байна.	90%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	боловсруулж батлуулна.			эмнэлзүйн заавартай.			
						Зорилт 1. Хэрэгжилтийн дундаж хувь	68.0%
ЗОРИЛТ 2. ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
2.1	"Сувилагчийн гарын авлага" боловсруулж түгээнэ.	3,0	Эрсдэлээс сэргийлэх гарын авлагыг хүлээлгэн өгсөн сувилагчдын тоо	Сувилагч нарт зориулсан эрсдэлээс сэргийлэх гарын авлага байхгүй.	150 сувилагчид (100%) гарын авлага хүлээлгэн өгсөн байна.	-Японы мэргэжилтэн сувилагчтай хамтран "Сувилагчийн гарын авлага"-ын эхийг боловсруулж хяналтын шатанд байна. -Гарын авлагын санхүүгийн зардал 5-р сард батлагдсан ба 3-р улиралд хэвлэх төлөвлөгөөтэй.	70%
2.2	БСТ-4.6.2 Цусны бүлэг тохироогүй амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс заслын эмчилгээг нэвтрүүлнэ. (ABO incompatible LDLT)	-241,0 (ЭМДС) -Улсын төсөв	Батлуулсан эмнэл зүйн удирдамжийн тоо; Батлагдсан удирдамжийн дагуу мэс заслын эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Эмнэл зүйн удирдамж байхгүй. ABO incompatible LDLT мэс заслын эмчилгээ нэвтрүүлээгүй.	ХСҮТ-ийн Эмнэл зүйн хороогоор батлуулсан удирдамж-1. ABO incompatible LDLT мэс заслын эмчилгээг 2 өвчтөнд хийсэн байна.	-Удирдамжийн боловсруулалт 80%-ийн гүйцэтгэлтэй. -Плазмафарез эмчилгээнд шаардлагатай нэг удаагийн хэрэгслийн бэлэн байдал 100% хангагдсан. -Дархлаа дарангуйлах эмчилгээний өвөрмөц эмийн бэлэн байдал 100% хангагдсан. -Цусан дахь изоаглютинин А болон В-ийн лабораторийн сургалт явагдаж байна.	90%
2.3	Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд амьд донороос бөөр шилжүүлэн суулгах мэс засалд донорын бөөр авах	-52,0 (ЭМДС) -Улсын төсөв	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо; Хийсэн робот мэс заслын тоо	БНСУ-д Робот мэс заслын сургалтад 5 эмч, 2 сувилагч хамрагдаж бэлтгэгдсэн. 2025 онд 2 мэс засал амжилттай хийсэн.	Сургалтад 3 эмч хамрагдсан байна. Хийсэн робот мэс заслын тоо-1.	-Мэс заслын багийн ур чадварыг дэлхийн тэргүүний SNUH Сөүлийн үндэсний их сургуулийн эмнэлэгтэй хамтран ахисан түвшний сургалтанд хамруулахаар судалж байна. -2025-оос хойш нийт 5 хүнд бөөр шилжүүлэн суулгах мэс засал амжилттай хийгдсэн; бүх донорын бөөрийг хэвлийн дурангийн аргаар авсан. -Робот мэс заслын бэлтгэл ажил 100% хангагдсан. -2026 онд 6 тохиолдолд амжилттай хийгдсэн.	70%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	мэс засалд робот аргыг нэвтрүүлнэ.					Ойролцоогоор 15 мэс засал дууссаны дараа донор бөөрийг робот аргаар авах болно.	
2.4	Амьд болон тархины үхэлтэй донороос элэг, бөөр зэрэг шилжүүлэн суулгах мэс заслын шинэ технологийн аргыг /Simultaneous Liver And Kidney Transplantation/ нэвтрүүлнэ.	-120,0 (ЭМДС) -Улсын төсөв	Батлагдсан удирдамжийн тоо; Батлагдсан удирдамжийн дагуу мэс заслын эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо	Амьд болон тархины үхэлтэй донороос элэг, бөөр зэрэг шилжүүлэн суулгах мэс заслын технологи нэвтрээгүй.	Амьд болон тархины үхэлтэй донороос элэг, бөөр шилжүүлэн суулгах 1 эмнэл зүйн удирдамж боловсруулж, ХСҮТ-ийн Эмнэл зүйн хороогоор батлуулсан байна. Мэс заслын эмчилгээг 1 өвчтөнд хийсэн байна.	-Удирдамжийн боловсруулалт 70%-ийн гүйцэтгэлтэй. -Мэс заслын эм тариа болон нэг удаагийн хэрэгслийн бэлэн байдал 100% хангагдсан.	85%
2.5	Тархины үхэлтэй донороос нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс засал эмчилгээ хийх ажлын бэлтгэл ажлыг хангана.	Улсын төсөв	Сургалтад хамрагдсан эмч нарын тоо	Тархины үхэлтэй донороос нойр булчирхай шилжүүлэн суулгах мэс заслын сургалтад эмч, мэргэжилтэн суралцаагүй.	Тархины үхэлтэй донороос нойр булчирхай авах мэс заслын богино хугацааны сургалтад 3 эмч хамрагдсан байна.	Мэс засал эмчилгээний удирдамжийн боловсруулалт 75%-ийн гүйцэтгэлтэй. Дотоодын нөөц бололцоог ашиглан сургалтууд хийгдэж байна. Гадаадын богино хугацааны сургалтанд 2 эмч явуулахаар бэлтгэл ажлыг хангасан.	50%
2.6	Үйл ажиллагаатай чөлөөт далбангийн нөхөн сэргээх мэс	45,5 (ЭМДС)	Амжилттай хийгдсэн мэс заслын тоо	Үйл ажиллагаатай чөлөөт далбангийн нөхөн сэргээх мэс	Нөхөн сэргээх мэс заслыг 5 өвчтөнд	2026 оны хагас жилийн байдлаар мэс засалд заалттай үйлчлүүлэгч хандаагүй байна.	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	заслын эмчилгээг нэвтрүүлнэ.			заслын эмчилгээ хийгдэж байгаагүй.	амжилттай хийсэн байна.		
2.7	Бамбайн дурангийн мэс заслыг нэвтрүүлэх суурь түвшний ажлыг эхлүүлнэ.	10,0	Бамбайн дурангийн мэс заслын сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо; Ханган нийлүүлсэн багаж, хэрэгслийн тоо	Бамбайн дурангийн мэс заслаар бэлтгэгдсэн эмч байхгүй. Тоног төхөөрөмжийн судалгаа хийгдээгүй. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмж байхгүй.	Богино хугацааны гадаад сургалтад 2-өөс цөөнгүй эмч хамруулсан байна. Шаардлагатай багаж хэрэгслийг худалдан авсан байна.	Толгой, хүзүү нөхөн сэргээх мэдрэлийн мэс заслын тасгийн их эмч Э.Өнөболд 2026.05.29–06.08 ОХУ-ын Цыба нэрэмжит Хавдар судлалын төвд бамбай булчирхайн хавдрыг дурангийн аргаар авах мэс заслын сургалтанд хамрагдсан. Шаардлагатай тоног төхөөрөмж, нэг удаагийн хэрэглэгдэхүүний захиалга боловсруулж хүргүүлсэн.	75%
2.8	Тархины гүний, төвөгтэй байрлалтай хавдар, хавдар төст эмгэгийн дурангийн мэс засал эмчилгээг нэвтрүүлнэ.	(Төсөл)	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо; Дурангийн мэс заслын тоо	I шатны сургалтад 3 мэс заслын эмч, хими эмчилгээний 1 эмч, эрчимт эмчилгээний 1 эмч, мэдээгүйжүүлгийн 1 эмч хамрагдсан. Тоног төхөөрөмжөөр хангагдаагүй. 2025 онд 3 тохиолдолд дурангийн мэс засал хийгдсэн.	II шатны сүүлийн сургалтад 7 эмч хамрагдсан байна. Дурангийн мэс засал 1 тохиолдолд хийсэн байна.	ЭМХТ-ийн сургалтын хөтөлбөрт хамрагдсан. II ээлжийн сургалтын хуваарь товлогдохыг хүлээж байна. БНСУ-ын эмнэлэгт мэдрэлийн мэс заслын үндэсний багийн 2 эмч явахаар төлөвлөж байна.	50%
2.9	БСТ-4 1.4 ХСҮТ-ийн молекул генетикийн оношилгооны чадавхыг сайжруулж, NGS (Next Generation	900,0 (Төсөл)	Сиквенсийн арга (NGS)-аар хийсэн шинжилгээний нэр төрлийн тоо; Шинжилгээнд хамрагдсан өвчтөний тоо	NGS технологи нэвтрээгүй.	Сиквенсийн арга (NGS)-аар 2 төрлийн шинжилгээ хийсэн байна. Зонхилон тохиолдох хорт	NGS MiSeq i100 загварын төхөөрөмжийн 1 өрөө, ПГУ-ын өмнөх болон дараах 2 лабораторийн өрөөг бүрэн засварлаж тохижуулсан; төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн шаардлагын дагуу суурилуулсан. BRCA1/2 генийн NGS шинжилгээг хөх болон өндгөвчний хорт хавдартай 24 өвчтөнд	70%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	Sequencing) технологийг нэвтрүүлнэ.				хавдрын 100 өвчтөнд шинжилгээ хийсэн байна.	хийгдсэн; 6-д нь зөрэг тодорхойлогдсон. 250 өвчтөнд генетикийн шинжилгээ хийх худалдан авалт зохион байгуулсан. ЭМЯ болон AstraZeneca-тай хамтарсан санамж бичгийн хүрээнд жилд 300 өвчтөнд шинжилгээ хийхээр гэрээ байгуулсан.	
2.10	Шинээр нэвтрүүлсэн молекул генетикийн оношилгоо болох NGS (Next Generation Sequencing) чиглэлээр эмч, мэргэжилтнийг (лабораторийн эмч, техникч) багаар нь сургах, чадавхжуулна.	20,0	Сургалтад хамрагдсан эмч, лаборантын тоо	Сургалтад хамрагдсан эмч, лаборант байхгүй.	1 эмч, 2 лаборант сургалтад хамрагдсан байна.	NGS-ийн сургалтанд 2026.03.09–13-нд 1 эмч, 2 лаборант хамрагдсан.	100%
2.11	БСТ-4.9.1 Тархины хавдрын стереотактик туяаны мэс засал эмчилгээг (Stereotactic Radio Surgery) эмнэл зүйн практикт нэвтрүүлнэ.	-2,5 (ЭМДС) -Улсын төсөв - Төсөл	Батлагдсан эмнэл зүйн удирдамжийн тоо; Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо; Туяаны мэс засал эмчилгээ хийлгэсэн өвчтөний тоо	Австрийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр 2023 онд шинэ шугаман хурдасгуур суурилуулж SRS хийх тоног төхөөрөмжийн нөхцөл бүрдсэн. ОУАЭА-ийн төслөөр дозиметрийн багаж хүлээн авсан.	Эмнэлзүйн хороогоор батлагдсан SRS-ийн эмнэлзүйн удирдамж-1. Туяа эмчилгээний 1 баг сургалтад хамрагдсан байна. Туяаны мэс засал эмчилгээ ≥3	Хагалгааны дараах тархины үсэрхийлэлд SRS хийх эмнэлзүйн удирдамж боловсруулсан; батлуулах шатанд байна. АНУ-ын Бэйлор Анагаах Ухааны Коллежийн баг 2026.06.22-оос эхлэн 7 өдрийн сургалт хийх бэлтгэл ажил хангагдсан. 2026.06.22–26-нд Бэйлор коллежийн мэргэжилтнүүдтэй хамтран SRS эмчилгээг эхлүүлнэ.	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					өвчтөнд хийсэн байна.		
2.12	БСТ-4.9.2 Дотуур туяа эмчилгээний интерстициаль (эдийн завсрын) шинэ технологийг эмнэл зүйн практикт нэвтрүүлнэ.	-2,4 (ЭМДС) -Улсын төсөв - Төсөл	Батлагдсан эмнэл зүйн удирдамжийн тоо; Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо; Эд завсрын дотуур туяа (interstitial brachytherapy) эмчилгээ хийсэн өвчтөний тоо	СУАЭА-ийн MON6023 төслөөр шинэ аппарат, багаж хэрэгслийг 2025 онд хүлээн авсан. Эмч, мэргэжилтэн бэлтгэгдээгүй /0/. Эд завсрын дотуур туяа эмчилгээ хийгдээгүй.	Эмнэлзүйн хороогоор батлагдсан эмнэл зүйн удирдамж-1. Сургалтад 2 эмч, 1 физикч инженер хамрагдсан байна. Эд завсрын дотуур туяа эмчилгээг 15 өвчтөнд хийсэн байна.	Тайлагнах хугацаа болоогүй.	Тайлагнах хугацаа болоогүй
2.13	Хэвлийн өндөр хэмээр хийгдэх хими эмчилгээ (HIPEC)-г эмнэл зүйн практикт нэвтрүүлнэ.	100,0 (Улсын Төсөв)	Батлагдсан удирдамжийн тоо; Эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	Удирдамж боловсруулагдаагүй /0/. Эмчилгээ нэвтрээгүй.	Эмнэл зүйн хороогоор 1 удирдамж батлуулсан байна. HIPEC эмчилгээг 3 өвчтөнд хийсэн байна.	Хэвлийн хөндийн гялтан хальсны хавдрын үсэрхийлэлтэй өндгөвч, бүдүүн гэдэс, ходоод, мезотелиомын үед хийх циторедуктив мэс засал (ЦМЗ) болон HIPEC-ийг 2025 онд бэлтгэж, 2026 оноос нэвтрүүллээ. Удирдамж ЭМЯ-д хүргүүлсэн; батлуулах шатанд байна. 2026.05.06-нд Францын Thermasolutions компанийн мэргэжилтэн Dr. Bruno Lambard 70 мэргэжилтнийг хамарсан сургалт зохион байгуулсан. 2026.05.07–08-нд HIPEC-ийг 2 тохиолдолд амжилттай хийлээ.	80%
2.14	TARE (Transarterial Radioembolization) эмчилгээг эмнэл зүйн практикт нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангана.	100,0	Эмчилгээний сургалтад хамруулсан эмч, мэргэжилтний тоо; Батлуулсан удирдамжийн тоо	Сургалтад эмч, мэргэжилтэнүүд суралцаагүй. TARE эмчилгээний эмнэл зүйн удирдамж, заавар байхгүй.	1 эмч, 1 техникч сургалтад хамрагдсан байна. ХСҮТ-ийн Эмнэл зүйн хороогоор	1. TARE эмчилгээний сургалтанд эмч, техникчийг хамруулах талаар ОХУ-руу 2026 оны 7-р сард явж судалгаа хийхээр бэлтгэл хангасан. 2. Эмнэлзүйн удирдамжийг боловсруулж, ХСҮТ-ийн эмнэлзүйн	80%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					батлуулсан удирдамж-1.	хороогоор батлуулан ЭМЯ-д хүргүүлсэн; хяналтын шатанд байна.	
2.15	HAIC — Hepatic arterial infusion chemotherapy эмчилгээг эмнэл зүйн практикт нэвтрүүлнэ.	-Улсын төсөв - Төсөл	Батлуулсан удирдамжийн тоо; HAIC эмчилгээг хийсэн тохиолдлын тоо	Эмнэлзүйн удирдамж байхгүй. Эмчилгээнд хамрагдсан тохиолдол байхгүй.	ХСҮТ-ийн "Эмнэл зүйн хороо"-гоор батлуулсан удирдамж-1. HAIC эмчилгээг 10 тохиолдолд хийсэн байна.	1. Эмнэлзүйн удирдамжийг боловсруулж, ХСҮТ-ийн эмнэлзүйн хороогоор батлуулан ЭМЯ-д хүргүүлсэн; хяналтын шатанд байна. 2. HAIC эмчилгээг нэвтрүүлэхэд шаардагдах зардал, худалдан авалтын судалгааны шатанд байна.	60%
2.16	ХСҮТ-ийн харьяа Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвд хавдрын системийн эмчилгээг эхлүүлж, нутагшуулна.	2,500.0	Сургасан эмч, мэргэжилтнүүдийн тоо; Дэд төвд амбулаторийн үзлэгт хамрагдсан үйлчлүүлэгчдийн тоо; Хавдрын системийн эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Эмч, сувилагч байхгүй. Эм зүйч-бэлтгэгдээгүй. Эм найруулагч байхгүй.	Нийт 8 эмч, мэргэжилтэн сургалтад хамруулсан байна. Амбулаторийн үзлэгт хамрагдах үйлчлүүлэгчид ≥500 хүртэл. Хавдрын системийн эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчид ≥500 хүртэл.	-Хойд бүсийн дэд төвийн хими эмчилгээний эмч, сувилагч, эм зүйч, мэс заслын эмч, эмэгтэйчүүдийн мэс заслын эмч, мэдээгүйжүүлэгч эмч зэрэг нийт 10 гаруй эмч, мэргэжилтэнийг ХСҮТ-д ажлын байрны сургалтад хамруулсан. -Хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ сэдэвт 2 багц цагийн сургалт зохион байгуулж 60 эмч, мэргэжилтэн хамрагдсан. -Хавдрын системийн эмчилгээ хийх ЭМДС-гаар санхүүжилтэд оруулах гэрээ хийгдсэн.	60%
2.17	Халдвар хяналт, сэргийлэлтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	30,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 95.7%-тай.	Төлөвлөсөн ажлыг 90%-иас дээш хэрэгжүүлсэн байна.	ХСХ-ын үйл ажиллагааны дүрэм, орон тооны бус багийн гишүүд, ЭТҮХХ-ын сэргийлэлт хяналтыг сайжруулах хөтөлбөр бүхий ХСҮТ-ийн захирлын А/47 тоот тушаалыг 2026.04.01-нд шинэчлэн гаргасан. Халдварын сэргийлэлт хяналтын 2026 оны төлөвлөгөөг 4 зорилт, 35 үйл	85%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
						ажиллагаатайгаар баталгаажуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 85%.	
2.18	Канад улсын Laurel сантай хамтран цээжний хөндийн хавдрын дурангийн мэс засал хийнэ.	66,0 (ЭМДС)	Зохион байгуулсан сургалтын тоо; Хийгдсэн мэс заслын тоо	2016-2019, 2022-2025 онуудад хамтран нийт 50 мэс заслын ажилбарыг хамтран хийсэн.	Нийт 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна. 6 мэс засал хийсэн байна.	2026 оны 6-р сарын 22-30-ны хооронд Laurel сангийн эмч нарын багтай хамтран сургалт болон мэс заслын хагалгааг хийх бэлтгэл ажил бүрэн хангагдсан.	70%
2.19	Цахим бүртгэлд "One Call" үйлчлүүлэгчийг дуудах автомат системийг нэвтрүүлнэ.	7,8	Үйлчлүүлэгчийн хүлээгдлийн хугацаа /минутаар/	Систем нэвтрээгүй. Үйлчлүүлэгчийн хүлээх хугацаа 1 цаг.	Үйлчлүүлэгчийн хүлээх цагийг 30 минутаар бууруулсан байна.	Тайлагнах хугацаа болоогүй.	Тайлагнах хугацаа болоогүй
2.20	Маммографи шинжилгээнд илэрсэн микро шохойжилттой эдийг нарийн зүүгээр байршил тогтоож мэс заслын аргаар эд авч оношодруулах аргыг нэвтрүүлнэ. /Hook wire Localization/	20,0 (ЭМДС)	Хийгдсэн ажилбарын тоо; Байршил амжилттай тогтоосон хувь; Хүндрэлийн хувь	Микро шохойжилтын байршил тогтоох ажилбар хийгддэггүй.	Ажилбарын тоо-60 ба түүнээс цөөнгүй удаа хийсэн байна. Байршил тогтоох амжилт ≥95%. Хүндрэл ≤2%.	Маммографи шинжилгээнд илэрсэн микро шохойжилттой эдийн Hook wire Localization аргыг нэвтрүүлэхэд шаардагдах зүүний захиалга хийгдэж тендерт орсон.	30%
2.21	Компьютер томографийн оношилгоонд элэгний сегментаци, эзлэхүүн хэмжилт, цусан хангамжийн	1,0 (ЭМДС)	Нэвтрүүлсэн эмнэлзүйн аппликэйшний тоо	ХСҮТ-ийн Дүрс оношилгооны тасагт нэвтрээгүй.	Компьютер томографийн дүрс оношилгоонд эмнэлзүйн 3 аппликэйшнийг	Японы засгийн газрын 2026 оны санхүүгийн жилийн (2026JFY) техникийн хамтын ажиллагааны төсөлд тус төлөвлөгөөний дагуу төсөл бичиж илгээсэн.	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	үнэлгээний эмнэлзүйн аппликэйшнуудыг үе шаттайгаар нэвтрүүлнэ.				нэвтрүүлсэн байна.		
						Зорилт 2. Хэрэгжилтийн дундаж хувь	**67.1%**
ЗОРИЛТ 3. ХОРТ ХАВДРЫН СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ ЭРХЛЭХ							
3.1 Хорт хавдрын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллээр хангах							
3.1.1	БСТ-6 1.2 "Хавдар судлалын тулгамдсан асуудал-2026" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.	80,0	Салбар хуралдааны тоо; Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо; Оролцогчдын тоо	"Хавдар судлалын тулгамдсан асуудал-2025" ЭШХ-ыг үндсэн болон 5 салбар хуралдаанаар зохион байгуулж, нийт 550 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан.	Оролцогчдын тоо-300. Салбар хуралдааны тоо-5. Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо ≤50 хүргэсэн байна.	Тайлагнах хугацаа болоогүй.	Тайлагнах хугацаа болоогүй
3.1.2	Олон улсын Эрхтэн Шилжүүлэн Суулгалтын Конгресс (ICOT — International Congress of Organ Transplantation)-ыг зохион байгуулна.	15,0	Конгрессд оролцогчдын тоо	2024 онд ICOT-4 дэх удаагийн хурал Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдсан.	250 оролцогч конгрессд орсон байна.	2026 оны 6 сарын 4-6-нд Монголын элэг цөс нойр булчирхайн нийгэмлэг, Mongolian Organ Transplantation Association хамтран ICOT V Олон улсын хурлыг зохион байгуулсан. Хуралд Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн дүүргүүдийн нэгдсэн эмнэлгийн 300 гаруй эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүд оролцсон. Уг хурал Liver transplantation, Kidney Transplantation, Bone marrow transplantation гэсэн 3 дэд хуралдаанаас бүрдсэн ба БНСУ, Турк, Испани, Энэтхэг, БНХАУ, ОХУ зэрэг орнуудаас 12 илтгэл тавигдсан.	100%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
3.1.3	Зонхилон тохиолдох хорт хавдрын молекул генетикийн, орчны болон халдварын хүчин зүйлсийн харилцан хамаарлыг эсийн ба молекулын түвшинд судална.	300,0	Төсөл судалгааны ажлын хэрэгжилтийн хувь	Төсөл 50%-тай хэрэгжсэн.	Төслийн хэрэгжилт 80%-д хүрсэн байна.	-Хөхний хорт хавдар болон генетикийн хүчин зүйлийн хамаарлыг тодорхойлох молекул генетикийн судалгааг хийх гурвалсан гэрээ батлагдахад бэлэн болсон. -Судалгааны урвалж, нэг удаагийн хэрэгслийн судалгааг бэлдсэн. -БНХАУ, Монголын хамтарсан цөсний замын хорт хавдрын генетикийн зураглалыг тодорхойлох төслийн хяналтын бүлгийн сийвэнг цуглуулж дуусгасан; хавдрын эд цуглуулах ажил үргэлжилж байна. 2026 оны 3-р улиралд ЭМЯ-наас дээж зөөвөрлөх зөвшөөрөл авахаар төлөвлөж байна.	50%
3.1.4	Хавдар судлалын чиглэлээр нийтлэгдсэн эрдэм шинжилгээ, судалгаа, өгүүллийг цахимаар байршуулан түгээнэ.	2,0	Цахимд байршуулсан судалгааны ажлын тоо; Цахимд байршуулсан сэтгүүлийн тоо	Байхгүй.	2024-2026 онд гадаад, дотоодын сэтгүүлд хэвлэгдсэн 10 шинжилгээ, судалгааны өгүүллийг цахимд байршуулна. Хавдар судлал сэтгүүлийн сүүлийн 5 жилийн дугаарыг байршуулсан байна.	Хавдар судлалын чиглэлээр нийтлэгдсэн 200 гаруй эрдэм шинжилгээ, судалгаа, өгүүллийг ХСҮТ-ийн цахим хуудаст оруулах бэлтгэл ажлыг хангаж, 3-р улиралаас эхлэн хэрэгжүүлнэ.	50%
3.2 Хавдар судлалын салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх							
3.2.1	БСТ-4.13 Аймаг, дүүргийн хавдрын эмч, өрхийн эмч,	2,0	Зохион байгуулсан сургалтын тоо;	Хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр 400 эмч,	Танхимын болон цахим хэлбэрээр 8-	-Огилт, бөөлжилт, гиперкальцеми, түгжрэлийн үеийн хөнгөвчлөх эмчилгээ сэдэвт 3 удаагийн цахим сургалтыг аймаг,	50%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
	сувилагч нарын хөнгөвчлөх эмчилгээний онол, практикийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор танхимын болон цахим сургалт зохион байгуулна.		Сургалтад хамрагдсан эмч, сувилагчийн тоо; Сургалтын дараах мэдлэгийн үнэлгээний дундаж өсөлтийн хувь	эмнэлгийн мэргэжилтэн сургалт зохион байгуулсан. Мэдлэгийн үнэлгээний нэгдсэн дүн, өсөлт тогтоогдоогүй.	аас цөөнгүй сургалт зохион байгуулсан байна. Сургалтад 400 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна. Оролцогчдын мэдлэгийн дундаж үнэлгээ өмнөх түвшнээс 20-иос доошгүй хувиар өссөн байна.	дүүргийн хавдар, хөнгөвчлөх эмчилгээний 70 эмч нарыг хамруулаа. -Сургалтад хамрагдсан оролцогчдын мэдлэг шалгах сорилыг боловсруулж, 3-р улиралаас эхлэн сургалтын өмнөх, дараах түвшин үнэлэх бэлтгэл ажлыг хангав.	
3.2.2	"CODE BLUE" амь тэнссэн үеийн сургалтыг зохион байгуулна.	2,5	Сургалтад хамрагдсан ажилчдын эзлэх хувь	CODE BLUE амь тэнссэн үеийн сургалт зохион байгуулагдаагүй.	Эмнэлгийн нийт ажилчдын 70% ба түүнээс дээш нь тус сургалтад хамрагдсан байна.	ХСҮТ-ийн Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгийн 2 сургагч эмч CODE BLUE амь тэнссэн үеийн сургалтыг 4 удаа зохион байгуулж, 4 тасаг, алба, 100 гаруй эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж чадавхижууллаа.	80%
3.2.3	Аймгийн эмч, мэргэжилтнүүдэд хавдрын сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр цахим болон танхимын сургалт зохион байгуулна.	3,0	Зохион байгуулсан сургалтын тоо; Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	2023, 2024 онд орон нутгийн сэргээн засахын мэргэжилтнүүд ХСҮТ дээр Хавдрын олон мэргэжилтний багийн Сэргээн засах тусламж сэдэвт сургалтанд хамрагдсан.	2-4 удаагийн цахим болон танхимын сургалт зохион байгуулсан байна. 20-иос цөөнгүй эмч, мэргэжилтнүүд хамрагдсан байна.	"Хавдрын эсрэг хамтдаа үндэсний аян-2026" багийн бүрэлдэхүүнд сэргээн засахын эмч, мэргэжилтнүүд орж 2026 оны 6 сарын 15-аас Сэлэнгэ, Хөвсгөл, Дорнод аймгуудын эмнэлгийн мэргэжилтнүүдэд хавдрын сэргээн засах тусламж үйлчилгээний сургалтыг зохион байгуулахад шаардагдах гарын авлага, материал, хэрэгслийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	70%
						Зорилт 3. Хэрэгжилтийн дундаж хувь	**66.6%**

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
ЗОРИЛТ 4. САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАЖ, ХУУЛЬ ТОГТООМЖ, ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ, НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ ХИЙХ							
4.1	Олон улсын "Сувилагчдын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.	3,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 75%-тай.	Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.	"Сувилагчийн цогц чадамж-сувилагчийн үнэ цэнэ" уриан дор "ОУ-ын Сувилагчдын өдөр"-ийн ажлын төлөвлөгөөг 2 зорилт, 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хэрэгжилт 100%. Хэрэгжилтийн хүрээнд: 1. Eagle TV, Малчин ТВ, TV9, NTV, МУОНТВ, TV25 зэрэг 6 телевизийн нэвтрүүлэг, ярилцлага, мэдээнд 7 сувилагч оролцов. 2. ХСҮТ-ийн вэб сайт, Facebook группд 4 сувилагчийн төлөөлөл цуврал мэдээлэл, ярилцлага өгсөн. 3. Хавдрын сувилагчийн нэг өдөрлөг зохион байгуулсан. 4. Нэлттэй хаалганы өдөрлөг. 5. "Сувилагч танд баярлалаа 2026" улсын хэмжээний уулзалтанд 10 сувилагчийн төлөөлөл хамрагдсан.	100%
4.2	Шинээр ажилд орсон сувилагч, тусгай мэргэжилтэн нарт "Шинэ сувилагч, тусгай мэргэжилтэн 2026" өдөрлөг зохион байгуулна.	6,0	Өдөрлөгт хамрагдсан шинэ сувилагч, тусгай мэргэжилтний хувь	ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2025.11.13-ны А/76 тушаалаар өдөрлөг зохион байгуулсан. 38 шинэ сувилагч ажилд орсон ба өдөрлөгт 100% хамрагдсан.	Шинээр ажилд орсон сувилагч, тусгай мэргэжилтнийг 100% хамруулсан байна.	Тайлагнах хугацаа болоогүй.	Тайлагнах хугацаа болоогүй
4.3	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангана.	5,0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай.	Төлөвлөгөөний хэрэгжилт 100% байна.	Эрүүл мэндийн салбарын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загварын дагуу ХСҮТ-ийн хэмжээнд 13 заалттай авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталгаажуулж,	60%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
						хагас жилийн байдлаар 8 ажлыг хэрэгжүүлсэн.	
4.4	БСТ-8.1.1 Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	150,0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 87%-тай.	Хөтөлбөрийн хэрэгжилт 90%-иас дээш хэрэгжсэн байна.	ХСҮТ-ийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд: МУ-ын Засгийн газрын тогтоолын дагуу 2026 оны эхний хагас жилд 2 удаа үндсэн цалин нэмж, Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн цахим программд оруулан ажиллалаа. Сар бүр ажлыг дүгнэж, улирал тутамд үндсэн цалингийн 20 хүртэлх хувийн нэмэгдэл урамшуулал олгож байна. 2026 оны 1-р улиралд 501 ажилтанд үр дүнгийн урамшуулал олгосон. Хүүхдийн баярыг угтан 6-18 насны 600 гаруй хүүхдэд чихэргүй эрүүл мэндийн бэлэг гардуулсан; 18 сая төгрөг зарцуулсан. 2025-2026 оны хичээлийн жилд 1-р ангид элсэн орсон хүүхэдтэй 25 ажилтанд ажлын цагаас 30 минутын цалинтай чөлөө олгосон.	80%
4.5	БСТ-8.1.2 ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	50,0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	Төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай.	Хөтөлбөр ≤93% биелэлттэй хэрэгжсэн байна.	ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд: -2026 оны 1-р улиралд нийт ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан; 96% хамрагдсан. -Байгууллагын 5 төрлийн спортын арга хэмжээг амжилттай зохион байгуулсан. -2026 оны 5-р сард Улаанбаатар марафон-2026 тэмцээнд 5, 10, 21 км-ийн зайд нийтдээ 60 ажилтан оролцсон; бүртгэлийн хураамжид 2.3 сая төгрөг зарцуулсан. -5-р сард өндөр настан ажилтнуудад шугаман бүжгийн 1 сарын сургалт зохион байгуулж, хичээллэх байраар хангасан.	70%

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025 он)	2026 онд хүрэх зорилтот түвшин	Хэрэгжилт /Хэрэгжээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
4.6	Хавдар судлалын үндэсний 2-р төвийн ТЭЗҮ боловсруулах, батлуулна.	-	Батлагдсан ТЭЗҮ	Хийгдээгүй.	ТЭЗҮ батлагдсан байна.	МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор ажлын хэсгийг байгуулан, төслийн ажлыг эхлүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн захирамжаар 2024.12.18-нд байгуулагдсан ажлын хэсэг 2026.01.26-нд Ерөнхийлөгчийн өрөөнд Хавдар-2 барилгын макет болон ажлын явцыг танилцуулж хуралдсан. Монгол Улсын Сангийн сайд Б.Жавхлан 2026.03.10-нд БНСУ-ын Санхүү, эдийн засгийн сайд Гү Юн Чольтой уулзаж, "Хавдар судлалын үндэсний төв-2" төслийн хэрэгжилтийг түргэтгэх асуудлыг хэлэлцэж, ТЭЗҮ-ийг эрчимжүүлэхээр тохиролцлоо. 2026 оны байдлаар Урьдчилсан ТЭЗҮ хийгдсэн. Үндсэн ТЭЗҮ гараагүй байна Барилгын зураг төсвийн ажил 98%-ийн гүйцэтгэлтэй. Гадна тохижилтын ажил 63.7%-ийн гүйцэтгэлтэй: зүлэгжүүлэлт 6406 м2-аас 4805 м2 (75%), 794 мод суулгасан (85%), явган зам 4448 м2 (95%). 2026 оны төсөвт А,С блокийн барилгын ажлыг эхлүүлэхэд 34,445.4 сая төгрөг төсөвлөгдсөн.	50%
						Зорилт 4. Хэрэгжилтийн дундаж хувь	**72.0%**
						НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ	**68.4%**

Зорилт 1. Хорт хавдрын бүртгэл, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийг хангах — 10 арга хэмжээ, хэрэгжилт 68.0%

Зорилт 2. Хорт хавдрын лавлагаа тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах — 19 арга хэмжээ, хэрэгжилт 67.1%

Зорилт 3. Хорт хавдрын судалгаа, эрдэм шинжилгээ, сургалт эрхлэх —6 арга хэмжээ, хэрэгжилт 66.6%

Зорилт 4. Санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангаж, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, хяналт тавих, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх — 5 арга хэмжээ, хэрэгжилт 72.0%

Нийт 40 арга хэмжээ, хэрэгжилт 68.4%

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ	Ц.БАТБОЛД
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ	Э.ХИШИГДОРЖ
ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ — г	С.ХҮРЭЛСҮХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА	Ц.БАДАМСҮРЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН	С.ЭРДЭНЭСУВД

Эх сурвалжийн дэлгэрэнгүй мэдээлэл:

Алба: Удирдлага

Албан тушаал: Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Нэр: С.Эрдэнэсувд

Цахим шуудан: khyanaltshinjilgee@gmail.com

Утас: 11-450043